



ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК

**АЙТУУЛС ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ХАРААТ БУС
АУДИТОРЫН ТАЙЛАН**

Улаанбаатар 2020 он

Агуулга

1. АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ	2
2. АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
2.1 САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН.....	4
2.2. ОРЛОГО ҮР ДҮН БОЛОН.....	5
2.3. ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	6
2.4. МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН.....	7
3. ТАЙЛАГНАГЧ АЖ АХУЙН НЭГЖ	8
4. АУДИТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	10
5. ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ	10
6. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ЧУХАЛ ТООЦООЛОЛ БА ШИЙДЭЛ	12
7. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД	12
8. САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	20
8.1. Тодруулга – МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	20
8.2. Тодруулга – ДАНСНЫ АВЛАГА	20
8.3. Тодруулга – БУСАД АВЛАГА.....	21
8.4. Тодруулга – БАРАА МАТЕРИАЛ.....	21
8.5. Тодруулга – УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ.....	22
8.6. Тодруулга – ҮНДСЭН ХӨРӨНГӨ	22
8.7. Тодруулга – БИЕТ БУС ХӨРӨНГӨ.....	22
8.8. Тодруулга – УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ.....	22
8.9. Тодруулга – ДУУСААГҮЙ БАРИЛГА	23
8.10. Тодруулга – ДАНСНЫ ӨГЛӨГ	23
8.11. Тодруулга – ЦАЛИНГИЙН ӨГЛӨГ.....	23
8.12. Тодруулга – ТАТВАРЫН ӨГЛӨГ	23
8.13. Тодруулга – НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ӨГЛӨГ.....	24
8.14. Тодруулга -НОГДОЛ АШГИЙН ӨГЛӨГ	24
8.15. Тодруулга -БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР.....	24
8.16. Тодруулга -УРЬДЧИЛЖ ОРСОН ОРЛОГО.....	24
8.17. Тодруулга – ХУВИЙН ӨМЧ.....	25
8.18. Тодруулга – БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, ӨРТӨГ	25
8.19. Тодруулга – БУСАД ОРЛОГО.....	25
8.20. Тодруулга – ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	25
8.21. Тодруулга – БУСАД ЗАРДАЛ.....	26
8.22. Тодруулга – ТАТВАРЫН ТООЦООЛОЛ.....	26
8.23. Тодруулга – ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ.....	27
8.24. Тодруулга – БОЛЗОШГҮЙ ЗҮЙЛ	27
8.25. Тодруулга – БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ	27

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУСЗ	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл
НББОУСЗ	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТТХ	Санхүүгийн Тайлагналын Тайлбарын Хороо
ТУЗ	Төлөөлөн Удирдах Зөвлөл
ААНОАТ	Аж Ахуйн Нэгжийн Орлогын Албан татвар
НӨАТ	Нэмэгдсэн Өртгийн Албан татвар
ХХОАТ	Хувь Хүний Орлогын Албан татвар
ИДШ	Иийгмийн даатгалын шимтээл
УОО	Урьдчилж Орсон Орлого

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК

Нягтлан бодох бүртгэл, татварын зөвлөх үйлчилгээ
2705958, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо
Метро бизнес төв А корпус 8 давхар
Утас факс: 99170900, 70117179
Email: info@goldenpageaudit.mn

АЙТҮҮЛС ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

2020.03.30 № А/18

танаа _____ -ны № _____ -т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Зөрчилгүй санал дүгнэлт

Бид Айтүүлс ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-нээрх Санхүүгийн байдлын тайлан, тайлант жилийн Ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, бусад тайлбар гэдруулгуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр, эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг талаараа Айтүүлс ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу, Сангийн яамнаас баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ууд болон Монгол улсад мөрдөгдөж буй холбогдох хууль, тогтоомжуудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлага энэ тайлангийнхаа *Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага* гэсэн хэсэгт харуулав.

Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд Монгол Улсын Мэргэшсэн нягтлан бодогчдын институтын Удирдах зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 29-ний хурлаар баталсан Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм, Олон улсын нягтлан бодогчдын холбооноос гаргасан “Нягтлан бодогчийн ёс зүйн дүрэм”-ийн 290-р бүлэг “Аудит болон нягтлах ажлын хараат бус байдал” болон 291 дүгээр бүлэг “Бусад баталгаажуулах ажлын хараат бус байдал”-д шаардсан ёс зүйн шаардлагуудыг мөрдсөн болно.

Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-уудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН-үргэлжлэл

эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь байгууллагын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн Тайлангийн Аудитад Аудиторын хүлээх Үүрэг Хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийн байгаа илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 95.1-р зүйлд заасны дагуу Айтүүлс ХК-ийн эрх бүхий этгээдэд танилцуулахад зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.



С.Оюунгэрэл

Захирал, МНБ


Огноо: 2020.03.30

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6 дугаар хороо

Метро бизнес төв А корпус 8 давхар 801 тоот

Утас факс: 99170900, 70117179

Email: info@goldenpageaudit.mn



2. АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН****ХӨРӨНГӨ**

Үзүүлэлт	Тодруулга	2018.12.31	2019.12.31
1. Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	8.1.	28,763,843.20	74,549,059.78
Дансны авлага	8.2.	181,146,590.54	1,191,941,599.92
Бусад авлага	8.3.	321,188,924.98	14,319,134.85
Бараа материал	8.4.	90,355,536.92	106,531,745.03
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	8.5.	520,510,397.89	244,705,357.81
Эргэлтийн хөрөнгийн дүн		1,141,965,293.53	1,632,046,897.39
2. Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	8.6.	2,256,421,417.02	1,471,806,885.29
Биет бус хөрөнгө	8.7.	132,249,430.91	124,289,390.91
Урт хугацаат хөрөнгө оруулалт	8.8.	70,446,145.00	70,446,145.00
Дуусаагүй барилга	8.9.		1,008,172,180.44
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		2,459,116,992.93	2,674,714,601.64
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		3,601,082,286.46	4,306,761,499.03
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ			
1. Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг	8.10.	60,175,907.30	86,486,613.79
Цалингийн өглөг	8.11.	3,918,681.22	-
Татварын өглөг	8.12.	121,357,313.20	95,313,159.95
НДШ-ийн өглөг	8.13.	3,165,291.79	-
Ногдол ашгийн өглөг	8.14.	-	-
Бусад богино хугацаат өр төлбөр	8.15.	173,168,708.51	624,329,713.18
Урьдчилж орсон орлого	8.16.	245,745,030.17	301,049,901.31
Богино хугацаат өр төлбөрийн дүн		607,530,932.20	1,107,179,388.23
2. Урт хугацаат өр төлбөр			
Хойшлогдсон татварын өр			-
Урт хугацаат өр төлбөрийн дүн		-	-
Өр төлбөрийн нийт дүн		607,530,932.20	1,107,179,388.23
Эзэмшигчдийн өмч			
Өмч: а) Хувийн	8.17.	905,758,223.28	905,758,223.28
б) хувьцаат	8.17.	1,338,798,000.00	1,338,798,000.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нөөц	8.17.	460,721,652.19	460,721,652.19
Хуримтлагдсан ашиг /алдагдал/	8.17.	288,273,478.79	494,304,235.34
Эзэмшигчдийн өмчийн дүн		2,993,551,354.26	3,199,582,110.81
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН		3,601,082,286.46	4,306,761,499.03

2.2. ОРЛОГО ҮР ДҮН БОЛОН

БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

Үзүүлэлт	Тодруулга	2018.12.31	2019.12.31
Үндсэн үйл ажиллагааны орлого	8.18.	1,512,815,765.71	3,086,784,553.85
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	8.18.	597,985,826.33	2,385,417,057.62
Нийт ашиг (алдагдал)		914,829,939.38	701,367,496.23
Түрээсийн орлого	8.18.	10,909,090.91	19,319,788.18
Хүүгийн орлого	8.18.	428,578.78	1,047,983.03
Ногдол ашгийн орлого		-	-
Эрхийн шимтгэлийн орлого		-	-
Бусад орлого	8.19.	162,250.61	34,739,758.37
Борлуулалт маркетингийн зардал		-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	8.20.	742,679,505.80	508,025,927.46
Санхүүгийн зардал		-	-
Бусад зардал /ҮАБЗ/	8.21.	7,732,045.00	18,153,957.24
Гадаад валютын ханшийн зөрүүний олз/гарз/	8.21.	5,945,174.58	2,556,469.40
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	8.21.	9,331,455.45	(1,911,441.31)
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз /гарз/		-	-
Бусад ашиг /алдагдал/		-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		191,194,938.91	230,940,169.20
Орлогын татварын зардал	8.22.	19,892,698.39	24,909,412.61
Хойшлогдсон татварын зардал /орлого/		-	-
Татварын дараах ашиг /алдагдал/		171,302,240.52	206,030,756.56
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/		-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		171,302,240.52	206,030,756.56
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүүний нөөц		-	-
Бусад олз /гарз/		-	-
Орлогын нийт дүн		171,302,240.52	206,030,756.56

2.3. ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгө дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,244,556,223.28	460,721,652.19	116,971,238.27	2,822,249,113.74
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	2,244,556,223.28	460,721,652.19	116,971,238.27	2,822,249,113.74
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	171,302,240.52	171,302,240.52
Өмчит гарсан өөрчлөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,244,556,223.28	460,721,652.19	288,273,478.79	2,993,551,354.26
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	2,244,556,223.28	460,721,652.19	288,273,478.79	2,993,551,354.26
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	206,030,756.55	206,030,756.55
Өмчит гарсан өөрчлөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,244,556,223.28	460,721,652.19	494,304,235.34	3,199,582,110.81

2.4. МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	1,372,857,881.66	3,033,214,758.05
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,364,966,032.05	2,654,913,061.87
Бусад мөнгөн орлого	7,891,849.61	378,301,696.18
<u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	1,423,608,626.87	2,789,160,803.51
Ажиллагчдад төлсөн	207,139,725.30	281,288,274.37
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	55,636,917.06	82,552,508.94
Бараа материал худалдан авахад төлсөн	467,504,826.36	1,486,393,842.43
Ашиглалтын зардалд төлсөн	108,879,938.60	172,974,297.56
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,999,666.37	4,283,489.86
Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн бусад мөнгө	-	2,750,000.00
Татварын байгууллагад төлсөн	47,794,388.24	324,656,918.44
Бусад мөнгөн зарлага	533,653,164.94	434,267,471.91
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(50,750,745.21)	244,047,954.54
2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	27,871,976.11	158,113,561.45
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	140,000.00	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	27,303,397.33	157,445,019.50
Хүлээн авсан хүүний орлого	428,578.78	668,541.95
<u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	131,235,527.50	457,740,846.77
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	338,821,811.00	310,932,037.69
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	95,413,716.50	146,808,809.08
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(406,363,551.39)	(299,627,285.32)
3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	124,022,327.65	364,295,286.00
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	124,022,327.65	364,295,286.00
<u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	56,098,120.00	266,372,088.54
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	56,098,120.00	266,372,088.54
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	67,924,207.65	97,923,197.46
Валютын ханшийн зөрүү	5,945,174.58	3,441,349.90
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(383,244,914.37)	45,063,185.51
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	412,008,757.57	28,763,843.20
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	28,763,843.20	74,549,059.78

3. ТАЙЛАГНАГЧ АЖ АХУЙН НЭГЖ

Айтүүлс ХК нь 2011 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр програм хангамж, мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар үүсгэн байгуулагдаж 9010001141 дугаар бүхий 5468361 регистрийн дугаартай гэрчилгээ авсан.

Айтүүлс ХК нь 2012 оноос эхлэн домэйн нэрийн бүртгэл, вэб хост, сервер байршуулалт, виртуал серверийн түрээс, и-мэйл сервисийн ашиглалт зэрэг интернет, мэдээллийн технологийн дэд бүтцэд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг аж ахуйн нэгж байгууллага, хувь хүмүүст үзүүлж тэдгээрийн аюулгүй байдал, найдвартай, тасралтгүй хэвийн үйл ажиллагааг 7 хоногийн 24 цагийн турш тасралтгүй хангасаар ирсэн.

Тус компани нь одоогоор 32 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нийлүүлж, 5340 гаруй харилцагчидтай болсон байна.

Компанийн дүрмийн сан нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 34,452,124 ширхэг энгийн хувьцаатай 3,445,212,400 төгрөгийн үнийн дүнтэй байна. Нийт 1248 хувьцаа эзэмшигчидтэй байна

- Монгол улсын оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2016.11.11-ний өдрийн А/314 тоот тушаалаар барааны тэмдгийг эзэмших онцгой эрхийн 201600970 дугаартай гэрчилгээг 2026.03.10 ны хүртэл олгосон.
- Айтүүлс ХК нь эзэмшлийн Дархан-Уул аймгийн Дархан сум, 12-р баг, 7-р хороололд орших холбоо мэдээлэл дамжуулах станц Дата төвийн зориулалттай 4506102458 дугаартай 1500 м.кв талбайтай газартай.
- Дархан-Уул аймгийн Дархан сум, 12-р баг, 7-р орон сууц, үйлчилгээ, хүүхдийн цэцэрлэгийн зориулалттай нэгж талбарын 080100836 дугаартай 1000 м.кв газартай.
- **Дата центр:** Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 1-р хороо, Жигжиджав гудамж, 5/3 тоот хаягт байршилтай Y-2202024358 дугар гэрчилгээтэй, 72 мкв талбайтай, үйлчилгээний зориулалттай, зоорийн давхарын үл хөдлөх хөрөнгөтэй.
- **25 оффис:** 1960 онд ашиглалтанд орсон, БГД 2-р хороо, 2-р хороолол, Төмөр замын 34 байр 2 тоот, 3 давхар байрны 1 давхарт байрлах 3 өрөө, улсын бүртгэлийн Y-2205018687 дугаар орон сууцтай.
- Гүйцэтгэх захирлаар Б.Тамир ажиллаж, ерөнхий нягтлан бодогч Б.Өнөрбадрах санхүүгийн тайланг бэлтгэн гаргадаг.

Албан ёсны хаяг: Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Бага тойруу 49, Мэдээлэл Технологийн Үндэсний Парк 103 тоот, Улаанбаатар хот, Монгол улс

Утас: 7575-5585

И мэйл info@itools.mn Вэб сайт: www.itools.mn




Зорилго

Монгол орны газар зүйн онцлогт тулгуурлан бүтээн байгуулагдаж буй Модулятор дата төвийн паркыг ашиглалтанд оруулж нийгэм эдийн засгийн бүхий л салбарын компаниудад дэлхийн жишигт нийцсэн мэдээллийн технологийн дэд бүтцийн цогц үйлчилгээ буюу цахим мэдээллийн дамжуулалт, хадгалалтын үйлчилгээг үзүүлж тэдгээрийн ашиг орлого, өрсөлдөх чадварын нэмэгдүүлэх замаар богино хугацаанд эдийн засагт болон мэдээлэл технологийн салбарын хөгжилд хувь нэмрээ оруулах, дэлхийд өрсөлдөхүйц дата төвийн бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох.

Зорилт

- Айтүүлс ХК нь өнгөрөгч 4 жилийн хугацаанд Монголын вэб сайтын зах зээлийн 8.3 хувийг эзэлж байгаа бөгөөд энэхүү хурдцаараа өсвөл 2020 он гэхэд 18 хувийг боломжтой. Төсөл хэрэгжсэнээр зах зээлийг эзлэх хурдыг өсгөж, улмаар 2025 онд вэб сайтын зах зээлийн 35 хувийг эзлэх
- Орчин үеийн чиг хандлагыг тодорхойлж байгаа модулятор дата төвийн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлж, эх орондоо төдийгүй олон улсад үйлчилгээ үзүүлэх
- Нөөц дата төвийн үйлчилгээг модулятор дата төвийн парк байгуулах замаар зах зээлд шинээр нэвтрүүлэх
- Монгол улсын хэрэгцээнд албан буюу бизнес и мэйлийн үйлчилгээг 100 хувь гадаадаас импортолж байна. Төсөл хэрэгжсэнээр албан и мэйлийн үйлчилгээг дотоодоос хангахаар зорьж байна.



4. АУДИТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Аудитын компани:	Голден пэйж Аудит ХХК
Үйл ажиллагааны зөвшөөрөл:	Аудит баталгаажуулалтын үйл ажиллагааны 34-2002 дугаар тусгай зөвшөөрөлтэй бөгөөд 2023 оны 4 дүгээр сар хүртэл сунгуулсан.
Албан ёсны хаяг:	Компанийн өөрийн байр, Сүхбаатар дүүрэг, 6 дугаар хороо, Метро бизнес төв 8 давхар, 801 тоот Улаанбаатар хот, Монгол улс.

5. ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ

5.1. СТОУС-ын нийцэл

Айтүүлс ХК-ийн санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ууд болон Санхүүгийн Тайлагналын Тайлбарын Хороо (СТТХ)-оос гаргасан тайлбарууд, Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан СТОУС-ыг дагаж мөрдсөн болно.

Компанийн үйл ажиллагааны болоод тайлагнагч валют нь Монгол улсын Төгрөг байна. Эдгээр санхүүгийн тайлангууд нь Төгрөгөөр илэрхийлэгдсэн бөгөөд мянган төгрөгөөр нарийвчлан харуулж тайлагнасан.

СТОУС-ын дагуу санхүүгийн тайлан бэлтгэхэд тодорхой, чухал нягтлан бодох бүртгэлийн тооцоолол хийхийг шаарддаг. Мөн компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэглэхэд удирдлагаас шийдэл гаргахыг шаарддаг. Санхүүгийн тайлан бэлтгэхэд хийгдсэн нөлөө бүхий шийдэл ба тооцоолол, түүний нөлөөллийн талаар тайлангийн 4 дүгээр хэсэгт тодруулсан.

5.2. Хэмжилтийн үндэслэл

Айтүүлс ХК-ийн санхүүгийн тайлангууд нь дараах сууриар бэлтгэгдсэн.

- Гадаад валютаарх мөнгөн хөрөнгө – Монгол банкны хаалтын ханшаар
- Гадаад валютаарх худалдааны өр төлбөр – Монгол банкны хаалтын ханшаар
- Бусад санхүүгийн болоод санхүүгийн бус хөрөнгө өр төлбөрүүд – Түүхэн өртгөөр


5.3. Тасралтгүй үйл ажиллагааны зарчим

Тасралтгүй байх зарчмын дагуу компани өөрийн бизнесийг төсөөлж болох ирээдүйн хугацаанд үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөл дээр үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэнэ.

Хэрэв удирдлага компанийг татан буулгах, эсвэл үйл ажиллагааг нь зогсоохоор санаархаж байгаа буюу эсвэл тэгэхээс өөр ямар ч бодит боломжгүй байхаас бусад тохиолдолд ерөнхий зорилготой санхүүгийн тайлангуудыг тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэдэг.

Тасралтгүй байх таамаглалыг хэрэглэх нь зохимжтой бол тухайн компани бизнесийн хэвийн явцад хөрөнгөө хэрэгжүүлж, өр төлбөрөө барагдуулах боломжтой байна гэсэн үндэслэлээр хөрөнгө ба өр төлбөрийг бүртгэдэг.

5.4 Тайлангийн хугацаанд шинээр хэрэгжиж эхэлсэн стандартууд болон бусад стандартын нэмэлт өөрчлөлтүүд.



- **НББОУС 12 Орлогын татвар** “2015-2017 оны циклийн жилийн сайжруулалт”-ын үр дүнд гарсан нэмэлт өөрчлөлт (2017 оны 12-р сард гаргасан)
- **СТОУС 3 Бизнесийн нэгдэл ба СТОУС 11 Хамтарсан хэлцэл** “2015-2017 оны циклийн жилийн сайжруулалт”-ын үр дүнд гарсан нэмэлт өөрчлөлт (2017 оны 12-р сард гаргасан)
- **НББОУС 23 Зээлийн зардал** “2015-2017 оны циклийн жилийн сайжруулалт”-ын үр дүнд гарсан нэмэлт өөрчлөлт (2017 оны 12-р сард гаргасан)
- **СТОУС 16 Түрээс** (2016 оны 1-р сард гаргасан)
- **НББОУС 19 “Ажилчдын тэтгэмж”-нд орсон нэмэлт өөрчлөлтүүд** (2018 оны 2-р сард гарсан нэмэлт өөрчлөлт)
- **СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр** Санхүүгийн өр төлбөрт оруулсан өөрчлөлтийг тодруулах болон сөрөг нөхөн төлбөртэй холбоотой урьдчилан төлсөн төлбөрийн талаар нэмэлт өөрчлөлт (2017 оны 10-р сард гаргасан)
- **НББОУС 28 Хараат болон хамтарсан компанид оруулсан хөрөнгө оруулалт** Хараат болон хамтарсан компанид оруулсан урт хугацааны оролцоотой холбоотой нэмэлт өөрчлөлт (2017 оны 10-р сард гаргасан)

Компани явуулж байгаа үйл ажиллагаатай уялдуулан дээрх стандартын хэрэглээ тохиолдвол хэрэгжүүлж ажиллах боломжтой.

5.5 2019 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн жилд заавал мөрдөхөөр заагаагүй стандартууд ба тайлбарууд шинээр батлагдаж, хэвлэн нийтлэгдсэн, эдгээрийг хугацаанаас өмнө хэрэгжүүлж эхлээгүй.

- **Санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын хүрээ дараах байдлаар өөрчлөгдсөн.**
Санхүүгийн тайлагналын үзэл баримтлалуудыг дараах шинж чанаруудаар бүлэглэсэн байна.
Бүлэг 1-Санхүүгийн тайлагналын зорилго
Бүлэг 2- Санхүүгийн мэдээллийн хэрэгцээтэй байдлын чанарын үзүүлэлтүүд
Бүлэг 3- Санхүүгийн тайлан болон тайлагнагч аж ахуйн нэгж
Бүлэг 4- Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд
Бүлэг 5- Хүлээн зөвшөөрөлт ба үл хүлээн зөвшөөрөлт
Бүлэг 6- Хэмжилт
Бүлэг 7- Толилуулга ба тодруулга
Бүлэг 8- Капиталын талаарх үзэл баримтлал/ойлголт ба капитал засвар
- **СТОУС 3 Бизнесийн нэгдэл- Бизнесийн тодорхойлолт** (2010 оны 10-р сард гарсан нэмэлт өөрчлөлт)
- **НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, НББОУС-8 нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа**
- **СТОУС-17 Даатгалын гэрээ-/Хамааралгүй/**



6. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ЧУХАЛ ТООЦООЛОЛ БА ШИЙДЭЛ

Компани нь ирээдүйн үйл ажиллагаатай холбоотой тодорхой тооцоолол ба төсөөлөл ашигладаг. Түүхэн туршлага болон үүссэн нөхцөл байдалд тохиромжтой гэж үзсэн ирээдүйн үйл ажиллагааны тухай таамаглал гэх мэт бусад хүчин зүйлсэд үндэслэн тооцоолол ба шийдлийг тогтмол үнэлдэг. Бодит үр дүн нь тооцоолол ба төсөөллөөс ялгаатай байж болно.

6.1 Элэгдүүлэх хөрөнгийн ашиглалтын хугацаа

Компанийн удирдлага нь хүлээгдэж буй хөрөнгийн ашиглалтад суурилан тайлант үе бүрийн эцэст биет хөрөнгө болон бусад тавилга эд хогшил, компьютер дагалдах хэрэгсэл зэрэг элэгдүүлдэг хөрөнгүүдийн ашиглалтын хугацааг шалгадаг. Гарсан үр дүн нь магадгүй техникийн хуучралтын улмаас тооцоолол ба төсөөллөөс ялгаатай байж болох юм.

7. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД

7.1. Санхүүгийн хөрөнгө

Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор, мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд гар дээрх мөнгө, санхүүгийн байгууллагад хадгалагдаж байгаа мөнгө, бусад богино хугацаатай, 3 сар эсвэл түүнээс богино хугацаанд мөнгө болох чадвартай, үнийн өөрчлөлтөд өртөмтгий бус хөрөнгө оруулалт болон банкны овердрафт багтана. Банкны овердрафтыг балансын эргэлтийн хөрөнгийн хэсэгт харуулна.

Анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Санхүүгийн хөрөнгийг анхны удаа түүний бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх ба бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгөөс бусад хөрөнгийн хувьд анхны хүлээн зөвшөөрөлтийн бодит үнэ цэнэд ажил гүйлгээний зардлыг нэмж оруулна. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн хувьд ажил гүйлгээний зардлыг тайлант үеийн ашиг алдагдалд тайлагнана.

Ангилал

Санхүүгийн хөрөнгийг дараа үеүдэд хэмжих зорилгоор дараах байдлаар ангилна.

(i) Дараагийн тайлант үе бүрт хорогдуулсан өртгөөр хэмжих

Зээл ба авлагууд нь идэвхтэй зах зээлийн жишиг үнэгүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөртэй, үүсмэл биш санхүүгийн хөрөнгүүд юм.

(ii) Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь тайлант үеийн ашиг алдагдлаар бүртгэгдэх

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгө нь арилжааны буюу ашиг олох зорилгоор худалдан аваад богино хугацаанд эргүүлэн худалдах зориулалттай хөрөнгө болон анхнаасаа бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгө гэж ангилсан хөрөнгүүдээс бүрдэнэ.

Идэвхтэй зах зээлийн жишиг үнэ байхгүй, бодит үнэ цэнийг нь хэмжих боломжгүй өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгө гэж ангилахгүй.

(iii) Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэгдэх

Тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөр ба тогтсон хугацаа байхгүй, дунд болон урт хугацаанд эзэмшихээр шийдсэн хөрөнгө оруулалт болон өмнө дурдсан ангиллуудын алинд ч багтаагүй санхүүгийн хөрөнгүүдийг энэ ангилалд багтаана.

7.2. Санхүүгийн хөрөнгийн дараа үеийн хэмжилт

Дараагийн тайлант үе бүрт хорогдуулсан өртгөөр хэмжих санхүүгийн хөрөнгийг үр ашигт хүүний арга ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжинэ.

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгийг дараа үеүдэд бодит үнэ цэнээр нь хэмжинэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, гарзыг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө.

- ✓ Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн хувьд ашиг, алдагдлын тайланд бусад орлого эсвэл бусад зардлаар
- ✓ Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэгдэх санхүүгийн хөрөнгийн хувьд дансны үнийн бусад өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогоор

7.3. Санхүүгийн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлт

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

- ✓ Санхүүгийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн урсгалыг хүлээж авах эрхийн хугацаа дууссан; эсвэл
- ✓ Компани нь санхүүгийн хоронгоо орж ирэх мөнгөн урсгалыг авах эрхийг шилжүүлсэн бөгөөд (а) санхүүгийн хөрөнгийн эрсдэл, өгөөж бүрэн шилжсэн; эсвэл (б) бүх эрсдэл, өгөөж болон хөрөнгийг шилжүүлээгүй боловч захирах эрхийг нь шилжүүлсэн байх

7.4. Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Тайлант хугацаа бүрийн эцэст санхүүгийн хөрөнгийн (эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн) үнэ цэнэ буурсан байх шинж байгаа эсэхийг үнэлнэ. Анх хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон нэг эсвэл хэд хэдэн үйл явдлаас шалтгаалан үнэ цэнийн бууралт бий болсныг харуулах бодитой нотолгоо байгаа бөгөөд уг үйл явдал нь санхүүгийн хөрөнгийн (эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн) ирээдүйн тооцоолсон мөнгөн урсгалд нөлөөлөхүйц, дүнг тооцоолох боломжтой байгаа үед зөвхөн санхүүгийн хөрөнгийг үнэ цэнэ буурсан гэж үзнэ.

7.5. Санхүүгийн өр төлбөр

Компани өр төлбөрийн зорилгоос хамаарч санхүүгийн өр төлбөрөө дараах хоёр ангиллын аль нэгээр нь ангилдаг.

- ✓ Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөр
- ✓ Бусад санхүүгийн өр төлбөр

Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөр

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөрт зөвхөн алдагдалтай санхүүгийн үүсмэл хэрэглүүр багтана. Энэхүү ангилалд багтсан санхүүгийн өр төлбөрийг Санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь тусгаж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг Орлого үр дүнгийн тайланд тусгана. Ашиг олох зорилгоор бус харин эрсдэлээс хамгаалах зорилгоор үүсмэл хэрэглүүр эзэмшиж

гаргадаг. Эдгээр үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс бусад тохиолдолд арилжаалагдах зорилготой эсвэл бодит үнэ цэнийг нь ашиг, алдагдлаар нь хэмжих зорилготой санхүүгийн өр төлбөр байхгүй болно.

Бусад санхүүгийн өр төлбөр

Бусад санхүүгийн өр төлбөрт дараах зүйлс багтана.

- Банкны зээл болон бусад хүү тооцогдох санхүүгийн өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөхдөө тухайн хэрэглүүрийг гаргахтай шууд холбоотой зардлыг бодит үнэ цэнээс хассан дүнгээр бүртгэнэ. Ийм төрлийн хүүтэй өр төлбөрийг дараа үеүдэд бүртгэхдээ үр ашигт хүүний түвшинг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмждэг. Санхүүгийн өр төлбөрийн хүүний зардалд анхны ажил гүйлгээний зардал, эргэлтээс гаргах өдөр төлөгдөх аливаа нэмүү өртөг болон төлөгдөөгүй өрийн хүү, эсвэл купон багтана.
- Анх бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрсөн дансны өглөг ба бусад богино хугацаат мөнгөөрх өр төлбөрийг дараа үеүдэд үр ашигт хүүний түвшинг хэрэглэн хорогдуулсан өртгөөр хэмжинэ.

Компани санхүүгийн өр төлбөрийг тус өр төлбөртэй холбоотой үүрэг хариуцлага цуцлагдсан, чөлөөлөгдсөн болон хугацаа нь дуусгавар болсон үед үл хүлээн зөвшөөрнө.

7.6. Санхүүгийн бус хөрөнгө

Санхүүгийн хөрөнгөд санхүүгийн хөрөнгөөс бусад хөрөнгө багтана. Үүнд:

- Санхүүгийн бус авлага, урьдчилгаа
Бараа материал
- Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө гэх мэт

Анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Санхүүгийн бус хөрөнгүүдийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрөх ба өртөгт тухайн хөрөнгийг худалдан авахтай шууд холбоотой зардлууд багтана. Мөн өртөгт гадаад валютаар худалдан авсан хөрөнгийн мөнгөн урсгалын хэйджийн олз/гарзын өмчийн дүнгээс шилжүүлсэн хэсэг орно.

Санхүүгийн бус хөрөнгүүдийг тус бүрт нь толилуулах ба санхүүгийн байдлын тайланд толилуулагдана.

Тайлант хугацаа бүрийн эцэст санхүүгийн бус хөрөнгүүдийн дансны үнийг нягтлан үзэж үнэ цэнэ буурсан байх шинж байгаа эсэхийг тодорхойлно. Хэрэв үнэ цэнэ буурсан шинж илэрвэл хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцно.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар байгуулдаг ба элэгдүүлэх хугацаа нь ААНОАТ-ын тухай хуультай нийцдэг.

- | | |
|-------------------------------|--------|
| ▪ Барилга байгууламж | 40 жил |
| ▪ Машин тоног төхөөрөмж | 10 жил |
| ▪ Тавилга эд хогшил | 10 жил |
| ▪ Компьютер дагалдах хэрэгсэл | 3 жил |

7.7. Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Тайлант хугацаа бүрийн эцэст санхүүгийн бус хөрөнгүүдийн дансны үнийг нягтлан үзэж үнэ цэнэ буурсан байх шинж байгаа эсэхийг тодорхойлно. Хэрэв үнэ цэнэ буурсан шинж илэрвэл хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцно. Үнэ цэнийн бууралтыг шалгахдаа хөрөнгүүдийг бүлэглэх ба ингэхдээ бусад хөрөнгүүд болон мөнгө үүсгэгч нэгжүүдээс орох мөнгөн урсгалаас ангид, дангаараа цаашид үргэлжлүүлэн ашигласнаар мөнгөн орох урсгал бий болгох хөрөнгүүдийн хамгийн жижиг бүлэг байхаар бүлэглэнэ.

Тухайн хөрөнгө эсвэл мөнгө үүсгэгч нэгжийн нөхөгдөх дүнг ашиглалтын үнэ цэнэ болон бодит үнэ цэнээс борлуулахтай холбоотой зардлыг хассан цэвэр дүнгийн аль ихээр тооцно. Ашиглалтын үнэ цэнэ нь татварын өмнөх дискаунтын түвшин (мөнгөний үнэ цэнийн одоогийн зах зээлийн үнэлгээ болон тухайн хөрөнгө эсвэл мөнгө үүсгэгч нэгжийн эрсдэл зэргийг агуулсан)-г ашиглан ирээдүйн тооцсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнээр тооцогдоно.

Хөрөнгө эсвэл мөнгө үүсгэгч нэгжийн дансны үнэ нь нөхөгдөх дүнгээс их бол үнэ цэнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрнө.

7.8. Өөрийн хөрөнгө

Хувьцаат капитал

Энгийн хувьцааг өмчөөр ангилж тайлагнасан. Буцаан дуудах давуу эрхийн хувьцааг өр төлбөрөөр ангилж тайлагнана. Шинээр хувьцаа гаргахтай холбоотой шууд хуваарилагдах өсөн нэмэгдэх зардлыг аливаа татварын нөлөөг хассан дүнгээр нь өмчийн хэсэгт тайлагнасан.

Компани үүсгэн байгуулснаас хойш хугацаанд компанид хуримтлагдсан ашиг, алдагдлын нийлбэрийг хуримтлагдсан ашиг дансанд бүртгэх ба оруулсан хөрөнгийг ашиглан бий болгосон нэмэлт эх үүсвэрийн хэмжээг харуулна.

7.9. Харилцагчтай байгуулсан гэрээний орлого

Компани гэрээгээр амласан бүтээгдэхүүн үйлчилгээний хяналтыг харилцагчид шилжүүлсэн үед гэрээний үүргийг биелүүлсэн гэж үзэж орлогоо хүлээн зөвшөөрнө. Хяналтыг шилжүүлсэн эсэхийг үнэлэхдээ дараах хүчин зүйлсийг харгалзан үзнэ.

- Байгууллага хөрөнгөөс төлбөр хүлээн авах өнөөгийн эрхтэй эсэх
- Байгууллага хөрөнгийг биетээр шилжүүлсэн эсэх
- Хуулийн дагуу эзэмших эрхтэй эсэх
- Эзэмшлийн өгөөж ба эрсдэлийг хүлээх эсэх
- Харилцагч хөрөнгийг хүлээж авсан эсэх

Гэрээгээр амласан бүтээгдэхүүн үйлчилгээний хяналт нь тодорхой хугацааны турш эсвэл тодорхой нэг хугацаанд шилжиж болно.

Хяналт нь тодорхой хугацааны турш шилждэг бүтээгдэхүүн, үйлчилгээний орлогыг хүлээн зөвшөөрөхдөө гэрээгээр амласан бүтээгдэхүүн үйлчилгээний хяналтыг шилжүүлэхтэй холбоотой байгууллагын гүйцэтгэлтэй уялдуулан хүлээн зөвшөөрнө.

Харин гэрээгээр амласан бүтээгдэхүүн үйлчилгээний хяналт нь тодорхой нэг хугацаанд шилждэг буюу өөрөөр хэлбэл орлогыг тодорхой хугацааны турш хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаагүй бол орлогыг хяналт шилжсэн тэрхүү тодорхой нэг хугацаанд хүлээн зөвшөөрнө.

Гэрээгээр амласан бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчид нийлүүлснээр компанийн хүлээн авах эрхтэй болсон төлбөрийн дүнг ажил гүйлгээний үнэ гэх ба үүнд орлогын албан татвар, НӨАТ гэх мэт гуравдагч талын өмнөөс цуглуулсан дүн орохгүй. Харин хүлээн авах төлбөрийн мөн чанар, цаг хугацаа ба үнийн дүн, санхүүгийн элемент агуулсан эсэх, харилцагчид буцаан төлөх хөнгөлөлт, урамшуулал, буцаалт, гүйцэтгэлийн урамшуулал торгууль, болзошгүй төлбөрүүд, мөнгөн бус төлбөрүүд гэх мэт зүйлс нь ажил гүйлгээний үнэд нөлөөлнө.

7.9. Өртөг/Зардал

Тайлант хугацаанд хувь нийлүүлэгчид хуваарилснаас бусад шалтгааны улмаас мөнгөний гадагш урсгал хэлбэрээр хөрөнгийг бууруулж, өр төлбөр ихэсгэдэг эдийн засгийн өгөөжийн бууралт гарах үед зардлыг хүлээн зөвшөөрдөг.

Зардлыг тухайн гарсан жилд нь ашиг алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

7.10. Санхүүгийн орлого, зардал

Санхүүгийн орлогод харилцах, хадгаламжийн үлдэгдэлд бодогдсон хүүний орлого болон охин компани, бусад холбоотой бус талуудад олгосон зээлийн хүүний орлого, богино хугацаат бондын хүүний орлого зэргийг хамруулна. Хүүний орлогыг үр ашигт хүүний аргыг ашиглан орлого олсон тайлант үеийнх нь орлогын тайланд тусгана.

Санхүүгийн зардалд зээлийн хүүний зардлыг хамруулна. Капиталжуулах шаардлагыг хангасан хөрөнгийн худалдан авалт, барилгын ажил эсвэл үйлдвэрлэлтэй шууд хамааралтай капиталжуулсан зээлийн өртгөөс бусад бүх зээлийн хүүний зардлыг үр ашигт хүүний аргыг ашиглан тайлант үеийнх нь орлогын тайланд тусгана.

Зээлийн хүүний зардал

Бэлтгэл ажиллагаа шаардлагатай хөрөнгийг худалдан авах, барьж байгуулах эсвэл үйлдвэрлэлтэй шууд холбоотой тусгай болон ердийн зээлийн хүүний зардлыг ашиглах эсвэл борлуулахад бэлэн болгох зорилгоор хөрөнгийг бэлтгэх болон бүрэн дуусгахад шаардлагатай хугацааны туршид капиталжуулна. Бэлтгэл ажиллагаа шаардлагатай хөрөнгө гэдэг нь хөрөнгийг ашиглах эсвэл борлуулахад бэлэн болтол тодорхой хугацаа шаардлагатай хөрөнгийг хэлнэ.

Бэлтгэл ажиллагаа шаардлагатай хөрөнгийн зарцуулалтад тодорхой зээл авч богино хугацааны хөрөнгө оруулалт хийсэн хөрөнгө оруулалтын орлогыг капиталжуулах зээлийн хүүний зардлаас хасна.

Гадаад валютаарх ажил гүйлгээ ба үлдэгдэл

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөрийг тайлагналын өдрийн хаалтын ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлэн илэрхийлдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн ба бодит үнэ цэнээрээ хэмжигдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийг уг бодит үнэ цэнийг тодорхойлсон өдрийн албан ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлэн илэрхийлдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн ба түүхэн өртгөөр хэмжигдсэн мөнгөн бус зүйлсийг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар хөрвүүлдэг. Гадаад валютын ханшийн зөрүүг өрөнхийдөө ашиг эсвэл алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

Зээлтэй холбоотой ханшийн зөрүүний олз, гарзыг ашиг алдагдлын тайланд санхүүгийн зардалд багтаан тайлагнана. Бусад ханшийн зөрүүний олз, гарзыг ашиг алдагдлын тайланд бусад орлого эсвэл бусад зардлын цэвэр дүнгээр тайлагнана.

7.11. Түрээс

Түрээсийн гэрээний хүрээнд эзэмшиж буй ашиглах эрх бүхий хөрөнгө болон түүнтэй холбоотой түрээсийн өр төлбөрийг түрээсийн хугацааны эхэнд ашиглах эрхтэй хөрөнгө болон богино хугацаат эсвэл урт хугацаат өр төлбөрөөр хүлээн зөвшөөрч бүртгэх ба богино хугацаанд буюу 12 сарын хугацаатай эсвэл бага үнэ цэнэтэй түрээсээс бусад түрээсийн хувьд энэ зарчмаас чөлөөлөгдөхгүй. Түрээсийн гэрээний дагуу олж авсан ашиглах эрхтэй хөрөнгийг тус хөрөнгөөс хүртэж буй эдийн засгийн өгөөжтэй нь уялдуулан түрээсийн хугацаанд системтэйгээр ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг.

Богино хугацаат буюу 12 сарын хугацаатай эсвэл бага үнэ цэнэ бүхий түрээсийн хувьд түрээсийн үүрэг хариуцлагыг санхүүгийн зардлыг хассан цэвэр дүнгээр нь богино хугацаат өр төлбөрийн хэсэгт харуулдаг. Түрээсийн төлбөрийг өр төлбөр ба санхүүгийн зардал гэсэн 2 хэсэгт ангилна. Санхүүгийн зардлыг түрээсийн хугацааны туршид ашиг алдагдлын тайланд тусгах ба тайлант хугацаа бүрийн хувьд өр төлбөрийн үлдэгдэлд тооцогдох тогтмол хугацааны хүүг тооцоолох шаардлагатай. Урт хугацаат түрээсийн гэрээний дагуу олж авсан үндсэн хөрөнгийг хөрөнгийн ашиглалтын хугацаанд эсвэл түрээсийн хугацааны эцэст эзэмших эсэхийг тодорхойлох боломжгүй үед хөрөнгийн ашиглалтын хугацаа болон түрээсийн хугацааны аль богино хугацаанд элэгдүүлнэ.

7.12. Ажилчдын тэтгэмж

Ажилтан аж ахуйн нэгжид үзүүлсэн үйлчилгээний хариуд тайлант үеийн эцсээс хойших арван хоёр сарын хугацаанд багтаан авахаар тохиролцсон ажилтны тэтгэмж болох цалин, хөлс болон мөнгөн бус тэтгэмжүүдийг тайлант хугацааны эцсийг хүртэлх хугацаанд үзүүлсэн үйлчилгээнд суурилан хүлээн зөвшөөрөх ба төлбөрийг барагдуулах үед төлөгдөх дүнгээр хэмжинэ.

Ажилтны үйлчилгээ үзүүлсэн хугацаанаас хойш арван хоёр сараас илүү хугацаанд төлөгдөх бусад урт хугацааны тэтгэмжид удаан жил ажилласны тэтгэмж болон жилийн амралт зэрэг багтах ба төлөвлөсөн нэгжийн кредит аргыг ашиглан тайлант жилийн эцэс хүртэл үзүүлсэн үйлчилгээтэй нь уялдуулан ирээдүйн тооцоолсон төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр хэмжинэ.

Стандартаар заасан бусад хэлбэрүүд болох ажил эрхлэлтийн дараах тэтгэмж болон ажлаас халагдсаны тэтгэмж нь МУ-ын холбогдох хуулийн дагуу төрөөс төлөгддөг бөгөөд байгууллагын хувьд төлбөр төлөх үүрэг хүлээдэггүй.

7.13. Болзошгүй өр төлбөр

Өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, хүлээсэн үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад эдийн засгийн өгөөж бүхий нөөцийн урсгал гадагшлах магадлалтай болсон, мөн үүрэг хариуцлагын дүнг найдвартай тооцоолох боломжтой үед хуулийн зарга маргааны нэхэмжлэл, бүтээгдэхүүний баталгаа, гэрээний үүрэг хариуцлага зэргийг хүлээн зөвшөөрнө. Ирээдүйн үйл ажиллагааны алдагдалд зориулан болзошгүй өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй.

7.14. Татварын бүртгэл

Орлогын татвар

Орлогын албан татварыг тайлант үеийн эцэст хүчин төгөлдөр хэрэгжиж байсан хууль тогтоомжийн дагуу санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрнө. Орлогын албан татварын зардал нь тухайн жилийн татварын зардал болон хойшлогдсон татвараас

бүрдэх бөгөөд уг зардлуудтай холбоотой ажил гүйлгээ нь тухайн жил эсвэл өөр тайлант хугацаанд бусад дэлгэрэнгүй орлогод эсвэл өмчид шууд бүртгэснээс бусад тохиолдолд тухайн жилийн орлого, зарлагад хүлээн зөвшөөрөгдөнө.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр

Хойшлогдсон татвар нь санхүүгийн тайлагналын зорилгоор бүртгэсэн хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнэ ба татварын тайлагналын зорилгоор бүртгэсэн үнийн зөрүүнээс үүссэн түр зөрүү юм. Хойшлогдсон татварыг тайлагнах өдрөөрх болон цаашид хэрэгжих хуульд үндэслэн буцаалт хийгдэх түр зөрүүнд хэрэгжихээр хүлээгдэж байгаа татварын хувиар тооцдог.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг татвар ногдуулах нэг аж ахуйн нэгжид хамаарах татварын байгууллагаас тогтоосон тайлант үеийн татвар ногдуулах хөрөнгө, өр төлбөрийн эсрэг хуулийн эрх үүргийн дагуу хооронд нь хааж болох бөгөөд гэхдээ эдгээр татвар ногдуулах хөрөнгө, өр төлбөр нь цэвэр дүнд суурилсан байх хэрэгтэй. Ирээдүйн татвар ногдуулах ашиг нь татварын түр зөрүүг нөхөхүйц байх тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант үе бүрд хянаж холбогдох татварын өгөөжийг хэрэгжүүлэх буюу бууруулдаг.

НББОУС 12 болон ААНОАТ-ын тухай хууль тогтоомжийн зөрүүтэй байдал

Орлогын албан татварын байнгын болон түр зөрүүг хэрхэн тодорхойлж, тайлагнах талаар НББОУС 12 Орлогын албан татвар болон Сангийн Сайдын 121-р тогтоолоор батлагдсан "Санхүүгийн тайлангийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам"-ын зарим ойлголтууд хоорондоо зөрүүтэй байдаг.

Компани нь МУ-ын хууль тогтоомжоор шаардсаны дагуух татвар, шимтгэлийн төлөлт, ногдуулалт, тайлагналтай холбоотой бүх тооцоолол, бүртгэлийг өөрсдөө дотооддоо хийж гүйцэтгэдэг.


7.15. Холбоотой талууд

Холбоотой тал гэдэг нь санхүүгийн тайлан бэлтгэж байгаа байгууллагатай холбоотой хүн эсвэл байгууллага юм. Тухайн хүн эсвэл тэр хүний гэр бүлийн ойрын гишүүн нь тайлагнагч байгууллагатай холбоотой бөгөөд уг хүн нь:

- a) Тайлагнагч компанид хяналттай эсвэл хамтарсан хяналттай,
- b) Тайлагнагч компанид үлэмж хэмжээний нөлөөтэй,
- c) Тайлагнагч, тайлагнагчийн толгой компанийн гол удирдлагын багийн гишүүн байх,

Хэрэв дараах нөхцөлийн аль нэг оршин байгаа бол байгууллага нь тайлагнагчтай холбоотой гэж үзнэ. Үүнд:

- a) Байгууллага ба тайлагнагч нь нэг ижил байгууллагын (энэ нь толгой, охин болон дэд охин компани нь бусадтай холбоотой байх) гишүүд байх,
- b) Нэг байгууллага нөгөө байгууллагын хараат компани эсвэл хамтарсан үйлдвэр/хөрөнгө оруулалтын нэг тал нь байх (эсвэл нөгөө байгууллагын гишүүнчлэлтэй нэг гишүүний хараат компани эсвэл хамтарсан үйлдвэр/хөрөнгө оруулалтын нэг тал нь байх),
- c) Хоёр компани нь нэг ижил гуравдагч талын хамтарсан үйлдвэр/хөрөнгө оруулалтын талууд байх,
- d) Нэг байгууллага нь гуравдагч байгууллагын хамтарсан үйлдвэр/хамтарсан хөрөнгө оруулалтын нэг хэсэг болох ба нөгөө байгууллага нь гуравдагч байгууллагын хараат компани болох,



- е) Байгууллага нь тайлагнагч компани эсвэл тайлагнагч компанитай холбоотой байгууллагын аль алины ажилчдын тэтгэмжийн "ажил эрхлэлтийн дараах тогтоосон тэтгэмжийн төлөвлөгөө"-нд хамаарах. Хэрэв тайлагнагч нь өөрөө энэ төлөвлөгөөний нэг хэсэг бол спонсор ажил олгогчид нь тайлагнагчтай мөн холбоотой талууд болно.
- ф) Компанид (а)-д тодорхойлогдсон хүн хяналт тавьдаг эсвэл хамтарсан хяналт тавьдаг байх,
- g) (а), (а)-д тодорхойлогдсон хүн нь компанид үлэмж нөлөө үзүүлдэг эсвэл компанийн (эсвэл байгууллагын толгой компанийн) гол удирдлагын багийн гишүүн байх,

Байгууллага, эсвэл нэг хэсэг нь болж байгаа өөр бусад гишүүн, тайлагнагч эсвэл тайлагнагчийн толгой компани руу гол удирдлагын ажилтнаар хангах

8. САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

8.1. Тодруулга – МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Касс төгрөг	30,708.00	218,133.72
Пэй Пал Доллар	10,291.18	223,586.16
Харилцах /Голомт/ ₮ 1410002053	2,309,829.54	181,885.20
Харилцах /ХААН/ ₮ 5007783500	2,146,450.21	150,899.01
Харилцах /Төрийн банк/ ₮ 102100270510	22,476,654.26	25,445,650.74
Харилцах /ХХБ/ ₮ 499204437	1,480,212.24	92,703.89
Харилцах /Хас банк/ ₮	56,753.12	530,864.01
Петровис карт	-	586,626.00
Голомт банк /онлайн/	88,000.00	-
Кредит банк ₮	-	9,500.00
Харилцах Голомт \$ /1105058377/	95,990.86	86,953.59
Харилцах ХХБ \$ /499204438/	64,751.54	47,021,000.03
Харилцах ХХБ карт \$ /499205934/	4,202.24	1,257.42
ДҮН	28,763,843.20	74,549,059.78

Тус компани Хаан банк, Хас банк, Төрийн банк, Голомт банк, Кредит болон Худалдаа хөгжлийн банкуудад төгрөгийн 6 данс, долларын 3 данстай. Харилцахын үлдэгдлийг банкны тулган баталгаажуулалтаар баталгаажуулсан. Бэлэн мөнгөний үлдэгдэлд тооллого хийж, тооцоо бодоогүй. Энэ онд Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө нь өнгөрсөн оны үлдэгдлээс 45,063.2 мянган тогрөгөөр нэмэгдсэн байна.

8.2. Тодруулга – ДАНСНЫ АВЛАГА

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Авлага (харилцагч байгууллага)	23,214,180.32	20,178,856.32
Авлага (харилцагч байгууллага) Ньюс Эженси ХХК	462,000.00	-
Авлага (харилцагч байгууллага) АЖДХ	99,000,000.00	-
Авлага (харилцагч байгууллага) Unlimited LLC	25,225,868.25	-
Авлага (харилцагч байгууллага) Ядамын чулуун сан	29,134,600.00	-
Авлага (харилцагч байгууллага) Юнидата технологи ХХК	4,109,941.97	-
Авлага (харилцагч байгууллага) ХААБирж	-	770,000,000.00
Авлага (компани хоорондын)	-	1,032,043.85
Авлага (компани хоорондын) Ай Си Ти групп ХХК	-	153,261,908.90
Авлага (компани хоорондын) Клауд майнинг ХХК	-	104,315,796.88
Авлага (компани хоорондын) Айдэм ХХК	-	5,918,682.50
Авлага (компани хоорондын) Датасайнс ХХК	-	18,486,334.69
Авлага (компани хоорондын) Дижитал эксченж ХХК	-	7,487,186.14
Авлага (компани хоорондын) Синэт ХХК	-	5,529,771.74



Авлага (компани хоорондын) Ворлд саммит ХХК	-	1,126,500.00
Авлага (компани хоорондын) ЮБИСТОК ЭКСЧЕНЖ ХХК	-	57,953,588.00
Авлага (компани хоорондын) Нобел рийл эстэйт ХХК	-	21,674,930.00
Авлага (компани хоорондын) Стандарт капитал ХХК	-	7,422,713.98
Авлага (компани хоорондын) ICT market LLC	-	14,000,000.00
Авлага (ажилтан)	-	3,553,286.93
ДҮН	181,146,590.54	1,191,941,599.92

Дансны авлага өнгөрсөн оны мөн үеэс 1,010,795.0 мянган төгрөгөөр өссөн байна. Дансны авлага өссөн нь өнгөрсөн оныхоос борлуулалтын орлого өссөн, мөн ажил үйлчилгээ үзүүлсэн борлуулалтын авлагыг бусад авлагад бүртгэснийг залруулсантай холбоотой. Нийт дансны авлагаас хугацаа хэтэрсэн авлага 21,210.9 мянган төгрөг байна. Үлдэгдэл авлага нь төлөгдөх хугацаандаа байгаа хэвийн авлага. Авлагын үлдэгдэл тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажаагүй.

8.3. Тодруулга – БУСАД АВЛАГА

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Авлага (компани хоорондын)	465,200.00	
Авлага (компани хоорондын) Ай Си Ти групп ХХК	141,775,939.50	-
Авлага (компани хоорондын) Клауд майнинг ХХК	103,875,796.88	-
Авлага (компани хоорондын) Айдэм ХХК	3,539,292.50	-
Авлага (компани хоорондын) Дижитал эксченж ХХК	3,188,786.14	-
Авлага (компани хоорондын) Ворлд саммит ХХК	1,126,500.00	-
Авлага (компани хоорондын) ЮБИСТОК ЭКСЧЕНЖ ХХК	23,313,488.00	-
Авлага (компани хоорондын) Нобел рийл эстэйт ХХК	21,674,930.00	-
Авлага (компани хоорондын) Стандарт капитал ХХК	6,422,713.98	-
Авлага (ажилтан)	352,725.17	-
Авлага (ажилтан) гар утас	941,899.91	-
Авлага (хувь хүмүүс)	147,863.17	-
Авлага (хувь хүмүүс) Алтантулга	14,363,789.73	14,319,134.85
ДҮН	321,188,924.98	14,319,134.85

Бусад авлага буурсан нь өнгөрсөн оныхоос борлуулалтын орлого өссөнтэй холбоотой.

8.4. Тодруулга – БАРАА МАТЕРИАЛ

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Бараа материал	9,837,410.00	9,837,410.00
Хангамжийн материал	80,518,126.92	96,694,335.03
ДҮН	90,355,536.92	106,531,745.03

Хангамжийн материал өнгөрсөн жилийн мөн үеэс 16,176.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.



8.5. Тодруулга – УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Урьдчилж төлсөн зардал	242,642,397.89	229,705,357.81
Урьдчилж төлсөн тооцоо	277,868,000.00	15,000,000.00
ДҮН	520,510,397.89	244,705,357.81

Урьдчилж төлсөн зардал өнгөрсөн жилийн мөн үеэс 12,937.0 мянган төгрөгөөр буурсан байна. Ажил үйлчилгээний өртгийг урьдчилж төлсөн зардал дансанд хуримтлуулан хасагдуулж тооцдог. 2020 онд хийгдэх засварын үйл ажиллагаатай холбоотой бэлтгэн нийлүүлэгчид 15,000.0 мянган төгрөг урьдчилж төлсөн.

8.6. Тодруулга – ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Газар	694,176,147.08	694,176,147.08
Барилга байгууламж	350,446,375.71	350,446,375.71
Машин тоног төхөөрөмж	80,315,350.51	278,337,805.51
Тавилга эд хогшил	36,903,312.50	37,902,312.50
Компьютер дагалдах хэрэгсэл	242,296,845.74	349,346,007.60
Дуусаагүй барилга	1,008,172,180.44	-
Хур/элэгдэл (Барилга байгууламж)	(12,392,592.73)	(21,153,752.12)
Хур/элэгдэл (Машин тоног төхөөрөмж)	(15,121,767.61)	(30,157,980.35)
Хур/элэгдэл (Тавилга, эд хогшил)	(17,262,464.53)	(22,824,298.46)
Хур/элэгдэл (Компьютер дагалдах хэрэгсэл)	(111,111,970.11)	(164,265,732.18)
ДҮН	2,256,421,417.02	1,471,806,885.29

Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцохдоо шулуун шугамын аргыг ашигладаг. Ашиглалтын хугацаа үндсэн хөрөнгөөс хамаарч харилцан адилгүй. Тайланд онд компьютер дагалдах хэрэгсэл 107,042.2 мянган төгрөгөөр, тавилга эд хогшил 999.0 мянган төгрөгөөр, машин тоног төхөөрөмж 214,204.4 мянган төгрөгөөр тус тус өссөн.

8.7. Тодруулга – БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Биет бус хөрөнгө	140,653,115.01	145,768,115.01
Хур/хорогдол биет бус хөрөнгө	(8,403,684.10)	(21,478,724.10)
ДҮН	132,249,430.91	124,289,390.91

Тайланд онд биет бус хөрөнгө 5,115.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн. Даймонд санхүүгийн програм худалдан авсан.

8.8. Тодруулга – УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Охинд компанид оруулсан хөрөнгө оруулалт	70,446,145.0	70,446,145.0
ДҮН	70,446,145.0	70,446,145.0

Си нет ХХК-д 2017 онд оруулсан хөрөнгө оруулалт.



8.9. Тодруулга – ДУУСААГҮЙ БАРИЛГА

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Дуусаагүй барилга		- 1,008,172,180.44
ДҮН		- 1,008,172,180.44

Дархан хотод баригдаж буй Датацентр 60 хувьтай ажил хийгдсэн.

8.10. Тодруулга – ДАНСНЫ ӨГЛӨГ

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Өглөг (харилцагч байгууллага)	9,428,102.68	1,542,472.68
Өглөг (харилцагч байгууллага) Датаком ХХК	27,357,135.00	-
Өглөг (харилцагч байгууллага) Мобинет	-	-
Өглөг (харилцагч байгууллага) Мобиком ХХК 2015	1,010,000.00	1,010,000.00
Өглөг (харилцагч байгууллага) Жи мобайл нет ХХК	931,476.97	878,676.97
Өглөг (харилцагч байгууллага) Интерактив би ай ХХК	-	2,557,500.00
Өглөг (харилцагч байгууллага) Фибо Глобал ХХК	-	66,023,995.10
Өглөг (харилцагч байгууллага) Мобиком ХХК	319,470.65	-
Өглөг (харилцагч байгууллага) Вертексмон ХХК	21,129,722.00	5,547,030.00
Өглөг (харилцагч байгууллага) Синус Дочи ХХК		8,926,939.04
ДҮН	60,175,907.30	86,486,613.79

Тайлант онд дансны өглөг өмнө үеийнхээс 26,310.7 мянган төгрөгөөр өссөн байна. Өр төлбөр өссөн нь үндсэн хөрөнгийн худалдан авалт болон борлуулалт нэмэгдсэнтэй холбоотой. Хугацаа хэтэрсэн өр төлбөр үүсээгүй.

8.11. Тодруулга – ЦАЛИНГИЙН ӨГЛӨГ

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Өглөг (Цалин)	3,918,681.22	-
ДҮН	3,918,681.22	-

8.12. Тодруулга – ТАТВАРЫН ӨГЛӨГ

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
ААНОАТ-ын өглөг	10,596,406.66	19,246,488.36
НӨАТ-ын өглөг	125,733,396.19	61,002,313.14
НӨАТ-ын авлага хойшлуулсан	-20,433,285.25	-
ХХОАТ-ын өглөг	4,599,684.71	12,685,747.56
ХХОАТ-ын өглөг суутган	001,110.89	2,378,810.89
ДҮН	121,357,313.2	95,313,159.95

Татварын өр төлбөр өмнөх оноос 47,167.6 мянган төгрөгөөр буурсан.



8.13. Тодруулга – НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ӨГЛӨГ

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
НДШ-ийн өглөг	3,165,291.79	-
ДҮН	3,165,291.79	-

НДШ-ийн өр төлбөр үүсээгүй.

8.14. Тодруулга -НОГДОЛ АШГИЙН ӨГЛӨГ

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Ногдол ашгийн өглөг	-	-
ДҮН	-	-

Тайлант онд ногдол ашиг-олгоогүй байна.

8.15. Тодруулга -БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Өглөг (Хоорондын компани) Ай Си Ти групп ХХК	-	550,000,000.00
Өглөг (Хоорондын компани) Датасайнс ХХК	77,954,915.31	-
Өглөг (Хоорондын компани) Синэт ХХК	38,040,943.24	71,354,801.20
Өглөг (Хоорондын компани) Стандарт инвестмент ҮЦК	8,114,400.02	-
Өглөг (Хоорондын компани) Аиконтент ХХК	2,255,289.58	-
Өглөг (хувь хүмүүс)	200,000.00	0.00
Өглөг (хувь хүмүүс) Эрдэнэбат	25,042,010.15	-
Өглөг (хувь хүмүүс) Батзаяа Адилбиш	9,245,045.00	-
Өглөг (хувь хүмүүс) хоцролт	128,386.68	242,671.97
Өглөг (хувь хүмүүс) Мөнхтөр/Виртуал Ворлд	12,187,718.52	2,732,240.00
ДҮН	173,160,708.51	624,329,713.18

Тайлант онд бусад богино хугацааны өр төлбөр 451,161.0 мянган төгрөгөөр өссөн байна. Өр төлбөр өссөн нь холбоотой тал болох Ай си ти группд 550,000.0 мянган төгрөгийн өр нэмэгдсэнтэй холбоотой.

8.16. Тодруулга -УРЬДЧИЛЖ ОРСОН ОРЛОГО

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Урьдчилж орсон орлого	23,033.06	-
УОО- Хост /Си панель 1 домэйн/	51,953,541.55	56,631,535.31
УОО-Хост /Си панель, олон домэйн/	13,794,839.11	16,221,354.08
УОО-Хост реселлэр	251,378.64	711,026.68
УОО-Хост бизнес имэйл	30,780,552.17	46,803,898.55
УОО-VPS1	8,176,103.70	8,237,705.46
УОО-VPS2	9,984,205.73	12,358,918.72
УОО-VPS3	11,179,625.93	11,182,363.05
УОО-VPS4	6,839,371.12	13,370,006.76
УОО-Сервер байршуулалт 1-2unit	4,950,736.67	8,259,195.80
УОО-SSL123	10,608,500.04	19,695,637.21
УОО- .мн домэйн	76,740,478.09	89,044,173.28
УОО-.com .org .net домэйн	11,542,373.53	13,136,012.81
УОО-Сэргээх үйлчилгээ	-	240,986.04
УОО IP төлбөр	-	116,050.08
УОО- Бодит сервер түрээс	6,872,496.48	3,047,097.76
УОО-Багтаамж нэмэх	1,914,245.96	1,907,039.73
УОО-VPN үйлчилгээ	122,580.65	86,900.00

УОО- клауд майнинг байршуулалт	10,967.74	-
ДҮН	245,745,030.17	301,049,901.31

Бүтээгдэхүүн үйлчилгээгээ урт хугацаагаар үзүүлдэг бөгөөд хэрэглэгч, захиалагч, үйлчлүүлэгчдийн үйлчилгээний төлбөрийг урьдчилж авдаг ба тухайн үйлчилгээний хугацаагаар тайлант онд ногдох хэмжээгээр орсон орлогоо тайлагнасан байна. Урьдчилж орсон орлогын үлдэгдлийг харилцагч бүрээр тайлагнаагүй, орлогын төрлөөр тайлагнасан.

8.17. Тодруулга – ХУВИЙН ӨМЧ

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Өмч	905,758,223.28	905,758,223.28
Энгийн хувьцаа	1,338,798,000.00	1,338,798,000.00
Нэмж төлөгдсөн капитал	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	460,721,652.19	460,721,652.19
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
Тайлант үеийн ашиг, алдагдал	-	206,030,756.56
Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг, алдагдал	288,273,478.78	288,273,478.78
ДҮН	2,993,551,354.25	3,199,582,110.81

- Компанийн дүрмэнд нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 34,452,124.73 ширхэг энгийн хувьцаа, 1248 хувьцаа эзэмшигчтэй.
- 2017 онд хөрөнгө оруулалтын гэрээний дагуу эздийн өмчийг 1,338,798.0 мянган төгрөгөөр өөрчлөлт орсныг улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт хийлгэж, албажуулаагүй байна.
- Хөрөнгийн дахин үнэлгээ 2017 онд хийлгэсэн.
- Их хэмжээний болон сонирхлын хэлцэл хийгдсэн эсэх талаар тайлан, тодруулга бэлтгээгүй
- Үнэт цаасны арилжаатай холбоотой мэдээ, тайланг холбогдох аргачлал, маягтын дагуу бэлтгэж мэдээлээгүй байна.

8.18. Тодруулга – БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, ӨРТӨГ

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Борлуулалтын орлого	1,512,815,765.71	3,086,784,553.85
Борлуулалтын өртөг	597,985,826.33	2,385,417,057.62
Нийт ашиг	914,829,939.38	701,367,496.23

Борлуулалтын орлого нь үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлого, тендерийн борлуулалтын орлого, крипто фармын борлуулалтын орлогоос тус тус бүрдэж байна. Борлуулалтын хөнгөлөлт, урамшууллыг ойн баяр болон баяр ёслолын үед зарладаг.

8.19. Тодруулга – БУСАД ОРЛОГО

Орлогын төрөл	2018.12.31	2019.12.31
Бусад орлого	162,250.61	34,739,758.37
Түрээсийн орлого	10,909,090.91	19,319,788.18
Хүүгийн орлого	420,570.70	1,047,983.03
ДҮН	11,499,920.30	55,107,529.58

8.20. Тодруулга – ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

Зардлын төрөл	2018.12.31	2019.12.31
---------------	------------	------------

Ажиллагчдын цалингийн зардал	259,199,765.76	139,556,388.97
ТУЗ-НДШ,ЭМД	31,137,252.67	13,680,000.00
Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал	-	17,546,720.52
Аж ахуйн нэгжээс төлсөн ТУЗ НДШ-ийн зардал	-	2,133,535.41
Албан татвар,төлбөр,хураамжийн зардал	234,493.00	-
Томилолтын зардал	8,797,059.36	6,870,556.40
Бичиг хэргийн зардал	4,338,301.64	2,645,498.34
Шуудан холбооны зардал	52,393,886.93	15,324,887.05
Мэргэжлийн үйлчилгээний зардал	15,080,000.00	22,738,563.64
Сургалтын зардал	5,180,900.00	4,934,250.00
Ашиглалтын зардал	16,241,978.25	20,349,745.32
Засварын зардал	4,939,454.55	27,789,437.27
Элэгдэл, хорогдлын зардал	75,291,174.60	88,783,471.84
Түрээсийн зардал	87,412,924.86	65,456,363.59
Харуул хамгааллын зардал	8,049,585.25	1,600.00
Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	628,716.37	260,698.18
Тээврийн зардал	1,842,500.00	2,958,900.00
Шатахууны зардал	3,111,711.82	1,584,174.40
Хүлээн авалтын зардал	12,418,534.09	15,717,705.77
Лицензийн зардал	-	1,002,713.14
Зар сурталчилгааны зардал	43,486,843.48	33,116,011.81
Хүүгийн зардал	-	4,453,523.85
Хангамжийн зардал	7,495,036.31	2,501,017.07
Бусад зардал	98,348,645.06	18,914,649.73
Хандивын тусламжийн зардал	-	1,400,753.33
Банкны үйлчилгээний шимтгэл	7,050,741.80	3,377,679.06
ДҮН	742,679,505.80	513,098,844.70

8.21. Тодруулга – БУСАД ЗАРДАЛ

Зардлын төрөл	2018.12.31	2019.12.31
Алданги, торгуулийн зардал	7,482,045.00	-
Хандивын зардал	2,800,000.00	-
ДҮН	10,282,045.00	-

Гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарз


Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд хийсэн ханшийн тэгшитгэлийн ханшийн зөрүү	5,945,174.58	2,556,469.40
ДҮН	5,945,174.58	2,556,469.40

Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз, гарз

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз, гарз	9,331,455.45	(1,911,441.31)
ДҮН	9,331,455.45	(1,911,441.31)

8.22. Тодруулга – ТАТВАРЫН ТООЦООЛОЛ

	2018.12.31	2019.12.31
Татварын өмнөх ашиг, (алдагдал)	төгрөг 191,194,939	төгрөг 230,940,169
Байнгын зөрүү		
Хүүний орлого	-428,579	-1,047,983



Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал	-	18,153,957
Байнгын зөрүүгээр тохируулсан дүн	190,766,360	248,046,143
Түр зөрүү	-	-
Ханшийн зөрүүний бодит бус олз	-	-
Ханшийн зөрүүний бодит бус гарз	-	-
Түр зөрүүгээр тохируулсан дүн	-	-
Нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдуулах орлого	190,766,360	248,046,143
Ногдуулсан татвар	19,076,636	24,804,614
Тусгайлсан хувь хэмжээгээр татвар ногдуулах орлого, ногдох татвар	-428,579	-1,047,983
Ногдуулсан татвар	-42,858	-104,798
Нийт татварын зардал (өгөөж)	19,119,494	24,909,413

8.23. Тодруулга – ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ

Холбоотой талууд гэдэгт дараах этгээдүүд хамаарч байна.

Холбоотой тал	Хувьцааны тоо	Эзэмшлийн хувь
AFC UMBRELLA FUND	4,675,000	13.57
СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ	3,608,419	10.47
АЙ СИ ТИ ГРУПП ХХК	13,564,144	39.37
ДҮН	21,847,563	63.41

Компанийн 1245 хувьцаа эзэмшигчид нь нийт хувьцааны 12,604,561 ширхэг буюу 36.59 хувийг эзэмшиж байна.

Холбоотой талуудын сонирхлын хэлцэл хийсэн эсэх талаар тодруулга тайлан бэлтгээгүй.

8.24. Тодруулга – БОЛЗОШГҮЙ ЗҮЙЛ

Өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу эсвэл үүсмэл ямар нэг үүрэг хариуцлага байхгүй.

8.25. Тодруулга – БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

Компанийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн тайланг 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар аудит хийхэд санхүүгийн тайланд нөлөөлөхүйц үйл явдал гараагүй байна.

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК

УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ УЛС

2020 ОНЫ 03 ДУГААР
САРЫН 30-НЫ ӨДӨР

